



МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Утас: 31-03-92, Факс: (976-11) 31-14-71,
<http://www.mongolbank.mn>

2016.05.06 № A-1/519
танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНД

Банкны салбар дахь Засгийн газрын цэвэр зээлийн
2016 оны 1 дүгээр улирлын тайланг хүргүүлж байна.
Хавсралт 5 хуудастай.
Хувийг: Сангийн яаманд

Хүндэтгэсэн

ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.ЗОЛЖАРГАЛ

14 1999

A5-2016.doc

ТАНИЛЦУУЛГА

Банкны систем дэх Засгийн газрын цэвэр зээл (ЗГЦЗ)

Төв банк болон банкуудын нэгдсэн дүнгээр 2016 оны I улирлын эцэст Засгийн газрын өр төлбөр 3148.0 тэрбум төгрөг, хөрөнгө 3149.7 тэрбум төгрөг болж, ЗГЦЗ-ийн хэмжээ -1.7 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь ЗГЦЗ өнгөрсөн улирлаас 678.2 тэрбум төгрөгөөр буюу 100.3 хувиар буурсан үзүүлэлт байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Банкны систем дэх ЗГЦЗ (Монголбанкийг оруулсан дүн) (тэрбум ₮)

Хөрөнгө	ХИ.31	ШИ.31	Өөрчлөлт	Өр төлбөр	ХИ.31	ШИ.31	Өөрчлөлт
Төсвийн харилцах	559,4	798,3	238,9	ЗГҮЦ	2 747,4	2 761,8	14,5
Төгрөгийн	289,3	104,1	(185,2)	Богино хугацаатай	691,3	614,9	(76,5)
Валютын	270,2	694,2	424,1	Дунд хугацаатай	2 056,1	2 147,0	90,9
Нийгмийн даатгал	655,6	640,3	(15,3)	ЗГ-т олгосон зээл	-	292,5	292,5
ЗГ-ын санхүүжилт	498,8	1 184,3	685,5	Бусад	70,1	93,7	23,6
Бусад	427,1	526,8	99,7				
1.Нийт	2 140,9	3 149,7	1 008,8	2.Нийт	2 817,5	3 148,0	330,6
			ЗГЦЗ (2-1)		676,5	(1,7)	(678,2)

Банкны систем дэх Засгийн газар (ЗГ)-ын нийт өр төлбөр тайлант улиралд 330.6 тэрбум төгрөгөөр буюу 11.7 хувиар өссөн бол хөрөнгийн хэмжээ 1.0 их наяд төгрөгөөр буюу 47.1 хувиар өссөн байна.

Банкны систем дэх ЗГ-ын нийт өр төлбөрийн 16.8 хувь нь Монголбанкинд, 83.2 хувь нь банкуудад байршиж байгаа бол хөрөнгийн 28.7 хувь нь Монголбанкинд, 71.3 хувь нь банкуудад байршиж байна.

Төв банкин дахь ЗГЦЗ

Засгийн газар төсвийн улирлын чанартай орлого, зарлагын зөрүүг нөхөх зорилгоор Монголбанкнаас 200.0 тэрбум төгрөгийн зээл 2016 оны 3-р сарын 23-ны өдөр авсан. Монголбанк 2014 оны 12-р сард 195.0 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)-ыг Худалдаа, хөгжлийн банкнаас, 2016 оны 3-р сард 30.0 тэрбум төгрөгийн ЗГҮЦ-ыг Төрийн банкнаас тус тус худалдан авсан. Тайлант улиралд Засгийн газрын Монголбанкинд төлөх өр төлбөр нийт 322.2 тэрбум төгрөгөөр буюу 155.9 хувиар өсч, 528.9 тэрбум төгрөгт хүрчээ.

Монголбанкни дахь улсын төсвийн төгрөгийн харилцах дансны үлдэгдэл 185.2 тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч валютын харилцах 424.1 тэрбум төгрөгөөр өссөн нь ЗГ-ын нийт хөрөнгийн хэмжээ 215.4 тэрбум төгрөгөөр өсөх шалтгаан болжээ. Ийнхүү Төв банкин дахь ЗГЦЗ өмнөх улирлаас 106.9 тэрбум төгрөгөөр буюу 22.2 хувиар өсч, -373.5 тэрбум төгрөгт хүрсэн байна (Хүснэгт 2).


Хүснэгт 2. Төв банкин дахь ЗГЦЗ (тэрбум ₮)

Хөрөнгө	ХИ.31	ШИ.31	Өөрчлөлт	Өр төлбөр	ХИ.31	ШИ.31	Өөрчлөлт
Төсвийн харилцах	559,4	798,3	238,9	ЗГҮЦ	204,3	229,1	24,8
Төгрөгийн	289,3	104,1	(185,2)	ЗГ-т олгосон зээл	-	292,5	292,5
Валютын	270,2	694,2	424,1	Бусад	2,4	7,4	4,9
Бусад	127,6	104,1	(23,5)				
1.Нийт	687,1	902,4	215,4	2.Нийт	206,7	528,9	322,2
			Төв банкин дахь ЗГЦЗ (2-1)		(480,3)	(373,5)	106,9

Монголбанкин дахь ЗГ-ын нийт өр төлбөрийн 55.3 хувийг ЗГҮЦ, 43.3 хувийг ЗГ-ын зээл, 1.2 хувийг хуримтлагдсан хүүгийн өглөг эзэлж байна (Зураг 1а). ЗГ-ын нийт хөрөнгийн 77.0 хувь нь улсын төсвийн валютын харилцах дансанд, 11.5 хувь нь төгрөгийн харилцахад, 11.5 хувь нь бусад төрлийн дансанд¹ байна (Зураг 1б).


Зураг 1а. Төв банкин дахь ЗГ-ын өр төлбөр

Зураг 1б. Төв банкин дахь ЗГ-ын хөрөнгө



Зураг 2-оос харахад, 2014 оноос хойш Монголбанкин дахь ЗГЦЗ-ийн өөрчлөлтийг улсын төсвийн төгрөгийн болон валютын харилцах дансны өөрчлөлт голлон тайлбарлаж байна. ЗГЦЗ-ийн хэмжээ 2014 оноос хойш тогтмол өсөхөд төсвийн зарцуулалттай холбоотойгоор төгрөгийн болон валютын харилцах дансны үлдэгдэл буурсан; ЗГҮЦ, ЗГ-ын зээлийн хэмжээ өссөн нь нөлөөлжээ.

Зураг 2. Төв банкин дахь ЗГЦЗ (тэрбум ₮)



¹ Бусад төрлийн данс – Монголбанкин дахь улсын төсвийн төгрөгийн ба валютын нөөцийн данс, төслийн данс, KFW-ын данс, хуримтлуулж тооцсон хүүний авлага, ирээдүйн тэтгэврийн нөөц сан.

Харин 2015 оны 6-р сард Монгол Улсын Хөгжлийн банкны вексель төлөгдсөн, 2015 оны 12-р сард Засгийн газар Азийн Хөгжлийн банкнаас 100.0 сая ам.доллар, 2016 оны 3-р сард “Credit Suisse” банкнаас 250.0 сая ам.долларын зээл тус тус зээл авсан нь Төв банкин дахь ЗГЦЗ-ийн хэмжээ буурах үндэслэл болжээ.

Банкууд дахь ЗГЦЗ

Банкууд дахь ЗГ-ын өр төлбөрийн хэмжээ өмнөх улирлаас 8.3 тэрбум төгрөгөөр буюу 0.3 хувиар, хөрөнгийн хэмжээ 793.4 тэрбум төгрөгөөр буюу 54.6 хувиар тус тус өсчээ. Ингэснээр ЗГЦЗ-ийн хэмжээ 2015 оны 4 дүгээр улирлаас 785.1 тэрбум төгрөгөөр буюу 67.9 хувиар буурч 371.8 тэрбум төгрөгт хүрсэн байна (Хүснэгт 3).


Хүснэгт 3. Банкууд дахь ЗГЦЗ (тэрбум ₮)

Хөрөнгө	ХИ.З1	ШИ.З1	Өөрчлөлт	Өр төлбөр	ХИ.З1	ШИ.З1	Өөрчлөлт
Нийгмийн даатгал	655,6	640,3	(15,3)	Богино хугацаатай ЗГҮЦ	686,8	614,9	(72,0)
ЗГ-ын санхүүжилт	498,8	1 184,3	685,5	Дунд, урт хугацаатай ЗГҮЦ	1 856,3	1 917,9	61,6
Төгрөгийн хугацаатай хад.	-	170,3	170,3	Бусад	67,6	86,3	18,7
Бусад	299,5	252,3	(47,1)				
1.Нийт	1 453,9	2 247,3	793,4	2.Нийт	2 610,7	2 619,1	8,3
			Банкууд дахь ЗГЦЗ (2-1)		1 156,9	371,8	(785,1)

Банкуудад байршиж буй Засгийн газрын санхүүжилтийн хэмжээ 685.5 тэрбум төгрөгөөр, төгрөгийн хугацаатай хадгаламж 170.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь ЗГ-ын хөрөнгө өсөх нөлөө үзүүлжээ.

Банкууд дахь ЗГ-ын өр төлбөрийн 23.5 хувийг богино хугацаатай ЗГҮЦ², 73.2 хувийг дунд болон урт хугацаатай ЗГҮЦ³, 3.3 хувийг бусад төрлийн өр төлбөр⁴ эзэлжээ. ЗГ-ын нийт хөрөнгийн 28.5 хувь нь нийгмийн даатгал, 52.7 хувь нь ЗГ-ын санхүүжилт, 7.6 хувь нь төгрөгийн хугацаатай хадгаламж, 11.2 хувь нь бусад төрлийн хөрөнгө⁵ байна (Зураг 3а, 3б).

Зураг 3а. Банкууд дахь ЗГ-ын өр төлбөр



Зураг 3б. Банкууд дахь ЗГ-ын хөрөнгө



² 1 жил хүртэл хугацаатай ЗГҮЦ


³ 1-ээс дээш жилийн хугацаатай ЗГҮЦ

⁴ Бусад өр төлбөр – Банкууд дахь урьдчилж төлсөн ба хойшлогдсон татвар, хуримтлуулж тооцсон хүүний өглөг

⁵ Бусад хөрөнгө – Орлогын шилжүүлэг, улсын төсвийн тусгай данс, улсын төсвийн хадгаламж, орон нутгийн төсөв

Банкууд дахь ЗГЦЗ-ийн хэмжээ 2014 оны эхний хагаст харьцангуй тогтмол байсан бол 3 дугаар улирлаас эхлэн банкуудын эзэмшиж буй ЗГҮЦ-ны үлдэгдэл буурснаар ЗГЦЗ-ийн хэмжээ буурсан байна. Харин 2014 оны 11-р сараас эхлэн төсвийн зарцуулалттай холбоотойгоор банкуудад байршиж байсан ЗГ-ын төгрөгийн хугацаатай хадгаламжийн хэмжээ огцом буурсан, ЗГҮЦ-ыг Монголбанкаар дамжуулан банкуудад арилжаалах болсноор хэмжээ нь тогтмол өссөн нь ЗГЦЗ нэмэгдэх үндсэн шалтгаан болсон байна. Харин 2016 оны 3-р сард банкууд дахь ЗГ-ын санхүүжилтийн хэмжээ огцом нэмэгдсэн нь ЗГЦЗ-ийн хэмжээ буурахад нөлөөлжээ (Зураг 4).

Зураг 4. Банкууд дахь ЗГЦЗ (тэрбум ₮)



ЗГЦЗ-ийн тайланг банкуудаар болон системийн хэмжээгээр Хавсралт 1-д үзүүлэв.

ЗАСГИЙН ГАЗРЫН ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ТАЙЛАН

2016 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар

/сая төгрөгөөр/

ДАНС	БАНКУУД		Монголбанк		БҮГД ДҮН	
	Банкууд	Улирлын осолт /хувь/	Монголбанк	Улирлын осолт /хувь/	БҮГД ДҮН	Улирлын осолт /хувь/
1. Засгийн газрын өр төлбөр	2 619 078,0	0,3	528 946,6	155,9	3 148 024,6	11,7
Урьдчилж төлсөн ба хойшлогдсон татвар	11 719,0	21,1	-	-	11 719,0	21,1
ЗГ-ын богино хугацаатай үнэт цаас	614 855,8	(10,5)	-	(100,0)	614 855,8	(11,1)
ЗГ-ын дунд хугацаатай үнэт цаас	1 917 882,3	3,3	229 102,2	14,7	2 146 984,5	4,4
Хуримтлуулж тооцсон хүүний өглөг	74 620,8	28,8	7 350,4	202,4	81 971,3	35,7
Засгийн газрын зээл	-	-	292 494,0	100,0	292 494,0	100,0
ЗГ-ын бурад төрлийн өглөг	-	-	-	-	-	-
2. Засгийн газрын хөрөнгө	2 247 310,7	54,6	902 421,3	31,3	3 149 732,0	47,1
Улсын төсөв	2 226 246,8	55,2	902 421,3	31,3	3 128 668,1	47,5
Улсын төсвийн төгрөгийн харилцах	-	-	104 070,4	(64,0)	104 070,4	(64,0)
Улсын төсвийн төгрөгийн хугацаатай хадгаламж	170 314,8	90,9	-	-	170 314,8	90,9
Улсын төсвийн төгрөгийн хугацаагүй хадгаламж	95 328,3	11,7	-	-	95 328,3	11,7
Улсын төсвийн төгрөгийн нөөц	-	-	11 559,5	(81,2)	11 559,5	(81,2)
Улсын төсвийн валютын нөөц	-	-	51 465,5	2,7	51 465,5	2,7
Улсын төсвийн валютын харилцах	-	-	694 236,4	157,0	694 236,4	157,0
Улсын төсвийн валютын хугацаатай хадгаламж	3 295,8	100,0	-	-	3 295,8	100,0
Улсын төсвийн валютын хугацаагүй хадгаламж	1 951,3	549,1	-	-	1 951,3	549,1
Улсын төсвийн валютын данс (төсөл)	-	-	22 789,2	152,0	22 789,2	152,0
Орлогын шилжүүлэг (төгрөг)	3 988,9	86,9	-	-	3 988,9	86,9
Орлогын шилжүүлэг (валют)	-	(100,0)	-	-	-	(100,0)
Нийгмийн даатгал (төгрөг)	640 348,1	(2,3)	-	-	640 348,1	(2,3)
Нийгмийн даатгал (валют)	-	-	-	-	-	-
Тусгай данс (төгрөг)	102 382,8	36,6	-	-	102 382,8	36,6
Тусгай данс (валют)	24 327,6	(12,3)	-	-	24 327,6	(12,3)
Засгийн газрын санхүүжилт	1 184 309,2	137,4	-	-	1 184 309,2	137,4
Засгийн газрын авлага (KFW II)	-	-	7 220,5	6,2	7 220,5	6,2
Хуримтлуулж тооцсон хүүний авлага	-	-	90,1	187,6	90,1	187,6
Ирээдүйн тэтгэврийн нөөц сан	-	-	10 989,7	100,0	10 989,7	100,0
Орон нутгийн төсөв	21 063,9	6,4	-	-	21 063,9	6,4
Орон нутгийн тусгай данс (төгрөгийн)	8 302,2	12,8	-	-	8 302,2	12,8
Орон нутгийн тусгай данс (валютын)	12 761,7	2,6	-	-	12 761,7	2,6
3. ЗГ-ын цэвэр зээл (1-2)	371 767,3	(67,9)	(373 474,7)	(22,2)	(1 707,4)	(100,3)

Эх үүсвэр: Монголбанк болон банкуудын тайлан тэнцэл